

Бизнесийн Багц Даатгал Commercial Packaged Insurance Product (IF8)

Хичээл заах багш: Г.Энхтайван; Ч.Жалбуу



Хэрэгжүүлэгч



Хамтран хэрэгжүүлэгч



ОРШИЛ

Даатгалын салбар хөгжсөн орнуудад SME буюу жижиг-дунд бизнес эрхлэгчдэд зориулсан багцалсан даатгалын бүтээгдэхүүнүд түгээмэл хэрэглэгддэг бүтээгдэхүүн болж нэвтэрчээ.

Бизнес бүрт байдаг ижил, төстэй (хоможениус) эрсдэлүүдийг буюу 3-4 төрлийн даатгалыг нийлүүлж нэг даатгалын гэрээ бүхий бүтээгдэхүүн болгосон хөгжүүлэлтийг бизнесийн даатгал гэдэг.

Ингэж багцалснаар бизнес эрхлэгч, байгууллагуудад илүү хялбар, илүү тохирсон хамгаалалт болж очдог бол даатгагч үйл ажиллагааны зардлаа хэмнэдэг зэргээс авахуулаад олон давуу тал бий болдог.



Хичээлийн Агуулга

1. Бүлэг 1: Байгууллагын багц даатгалын үндэс
2. Бүлэг 2: Багц даатгалд багтдаг суурь бүтээгдэхүүнүүд



Бүлэг 1 - БАЙГУУЛЛАГЫН БАГЦ ДААТГАЛЫН ҮНДЭС

- 1.1 Хэрэглэгчээ таньж мэдэх нь – бизнесийн салбар
- 1.2 Зах зээл гэж юу вэ? – чөлөөт зах зээл
- 1.3 Багц даатгалын бүтээгдэхүүний хөгжилд Мэдээлэл Технологийн ашиг тус
- 1.4 Хяналт, Зохицуулалтын байгууллагын оролцоо
- 1.5 Хэрэглэгчид сайнаар, үнэнчээр хандах зарчим – Fair Treatment of Customer
- 1.6 Бүрэн стандартчилсан ба хагас стандартчилсан гэрээ (policy)
- 1.7 Дэмжих үйлчилгээнүүдийн ач холбогдол



Бүлэг 2 - БАГЦ ДААТГАЛЫН СУУРЬ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

- 2.1 Хөрөнгийн Даатгал
- 2.2 Даатгалд хамрагдах хөрөнгүүд ба бизнесийн хөрөнгийн орших хэлбэрүүдийг таньж мэдэх
- 2.3 Даатгалд хамрагдах эрсдэлүүд
- 2.4 Нэмэлт хамгаалалтууд (Extensions)
- 2.5 Хасалтууд
- 2.6 Бизнес Тасалдлын Даатгал
 - Борлуулалт ба үйлчилгээний хөлс
 - Үйл ажиллагааны нэмэгдэл зардал, өртгийн хамгаалалт – Increased cost of working
 - Бизнес Тасалдлын нэмэлт хамгаалалтууд (Extensions)
 - Бизнес Тасалдлын хасалтууд
- 2.7 Хариуцлагын Даатгал
 - Хариуцлагын даатгалын суурь философи ба түүний ажиллах зарчим
 - Хариуцлагын даатгалын хэлбэрүүд ба тэдгээрийн онцлог
 - Мэргэжлийн хариуцлагын даатгал ба түүний онцлог зарчмууд
 - Хариуцлагын даатгалын ерөнхий хасалтууд

Бүлэг 1: 1.1- Хэрэглэгчээ таньж мэдэх нь

Бизнес гэдэг нь амьдралаа авч явахын тулд эрхэлж буй аливаа бараа эсвэл үйлчилгээг бусдад зарах, нийлүүлэх замаар ашиг орлого олох зориулалттай үйл ажиллагаа билээ.

Бизнесийг хувь хүн дангаараа эсвэл хуулийн этгээд байгуулах буюу компани хэлбэрээр эрхэлж байна.



1.1- Хэрэглэгчээ таньж мэдэх нь Жижиг Дунд түвшний бизнесийн сегментийн гол үзүүлэлтүүд

Ажилтны тоо	1-10, цөөн тохиолдолд 50 хүртэл
Жилийн борлуулалт	0.5-2.4 тэрбум төгрөг
Үйл ажиллагаа явуулж буй ХХК-н тоо	+/- 40,000
Нийт Эдийн засагт эзлэх хувь	30%
Нийт ажиллах хүчинд эзлэх хувь	45%



1.1- Хэрэглэгчээ таньж мэдэх нь Жижиг Дунд түвшний бизнесийн сегментийн голлох чиглэлүүд

- Бар, ресторан, Нийтийн Хоолны үйлчилгээ
- Зочид буудал, байр сууцны үйлчилгээ
- Хүний эрүүл мэндийн үйл ажиллагаа
- Сургууль, Цэцэрлэг
- Аялал жуулчлал, бааз резорт
- Бэлэн бараа бүтээгдэхүүний бөөний, жижиглэнгийн худалдаа
- Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч
- Жижиг, дунд үйлдвэрлэл
- Нарийн Мэргэжилд суурилсан үйл ажиллагаа



1.1- Хэрэглэгчээ таньж мэдэх нь Жижиг Дунд түвшний бизнесийн сегментийн голлох чиглэлүүд (2)

Хүний Эрүүл Мэндийн үйл ажиллагаа

- Шүдний эмнэлэг
- Төрөлжсөн клиник
- Гоо сайхны эмнэлэг

Нарийн мэргэжлийн үйл ажиллагаа

- Архитектур, инженерийн мэргэжлийн компани
- Хууль зүйн туслалц, өмгөөллийн нөхөрлөл
- Үнэт цаас эсвэл даатгалын салбарын брокерын буюу “intermediary” компани
- Санхүү, аудит, нягтлан бодох бүртгэлийн туслалцаа, зөвлөх үйлчилгээний компани



1.1- Хэрэглэгчээ таньж мэдэх нь Бизнесийн байгууллагын хөрөнгийн хэлбэр

Үндсэн Хөрөнгө

- Барилга байгууламж
- Засал чимэглэл, тавилга эд хогшил

Бараа материал

Бизнесийн
Орлого

Тоног төхөөрөмж, машин механизм

- Үйлдвэрийн тоног төхөөрөмж
- Өөрөө явагч машин механизм

Санхүүгийн, мөнгөн хөрөнгө

- Хөрөнгө оруулалт
- Дансны үлдэгдэл

1.1- Хэрэглэгчээ таньж мэдэх нь Бизнесийн байгууллагын хариуцлагын хэлбэр

Биет хохиролд хүлээх хариуцлага (third-party liability)

- Бусдын амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд учрах хохирол
- Бусдын эд хөрөнгөд учрах хохирол

Мэргэжлийн хариуцлага (professional indemnity)

- Алдаатай зөвлөгөө, үйлчилгээнээс үйлчлүүлэгч хохирох, илүү зардлууд гарах

Эмнэлгийн хариуцлага (medical malpractice)



1.2 – Зах зээл гэж юу вэ?

Чөлөөт зах зээл

Market буюу зах зээл эсвэл зах гэдэг ойлголт нь нэг талаас худалдагч, нөгөө талаас худалдан авагч уулзаж, “бараа” / “бүтээгдэхүүн” зарах, худалдаж авах үйл явц өрнөдөг газар/орчныг хэлдэг.

Ихэнх зах чөлөөт шинжтэй (= free market) байдаг билээ. Жишээлэхэд үл хөдлөх хөрөнгийн зах: Орон сууцаа зарж буй тал бараагаа ямар үнээр зармаар байгаагаа олон нийтэд зарлаж нийтэлдэг. Худалдан авах тал тухайн үнэтэй санал нийлэхгүй бол өөрийн зорьж буй үнийг санал болгодог. Талууд чөлөөтэй тохиролцож, наймаа хийх эрхтэй байх ба тохиролцвол барааг өгч авалцана.

Зах зээл чөлөөтэй, талуудын сайн дурын хүрээнд байх нь илүү зөв, эрүүл байдаг.

Даатгалын захын хувьд хүнсний, өргөн хэрэглээний барааны зах шиг аль нэг биет газар, байршилд даатгагч, даатгуулагч бүгд цуглардаггүй ч, интернет орчинд имэйлээр, утсаар, эсвэл аль нэг талын оффист уулзах гэх мэт байдлаар зах зээлийн орчныг бүрдүүлж арилжаа, наймаа өрнөдөг.

Чөлөөт Даатгалын захын дүр зураг тэгвэл, нэг талд даатгал худалдаж авах хэрэгцээ, шаардлага бүхий байгууллагууд байх бол нөгөө талд тэдгээр байгууллагуудад зориулсан хоорондоо ижил, төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлж буй даатгалын компаниудын дунд худалдан авагч талд таалагдаж, сонгогдох хоорондын өрсөлдөөн байх учиртай билээ.

1.2 – Зах зээл гэж юу вэ? Бизнесийн Даатгалын Зах Зээл

Даатгал сайн хөгжсөн улс орнуудад байгууллагын даатгал сайн дурынх бөгөөд чөлөөт зах зээл давамгайлдаг байна.

Энэ утгаар бизнесийн сегментэд чигэлсэн даатгалын орчин асар өндөр өрсөлдөөнтэй байдаг.

Худалдан авагчид үнэ ба хамгаалалтын чанараар илүү гарах даатгалын компанийг өрсөлдөхүйц гэж үзэж байна. Тодруулбал, хямд үнээс гадна нийлүүлж буй даатгалын бүтээгдэхүүний хамгаалалтын цар хүрээ, худалдан авагчид тохирсон байдал ба нөхөн төлбөрийн үйлчилгээ тэрхүү амлалтынхаа дагуу шийдэгдэж байгаа эсэх гэж үзжээ.

Энэ нь даатгалын компанид ямар шаардлагыг тавьж байна гэж үзэх вэ? Чанартай даатгалын хамгаалалт, нөхөн төлбөрийн үйлчилгээг хамгийн өрсөлдөхүйц хямд үнээр нийлүүлэхийн тулд ухаалаг даатгагч дараах зүйлс дээр анхаардаг байна. Үүнд:

- Үйл ажиллагааны зардлыг бага байлгах
- Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг тогтмол хөгжүүлж, сайн байлгах



1.3 – Багц даатгалын бүтээгдэхүүний хөгжилд Мэдээлэл Технологийн ашиг тус (1)

Жижиг Дунд хэмжээний бизнесийн сегмент дараах онцлог ялгарах шинж чанартай байгаа билээ. Үүнд:

1. Эрсдэлийн ижилдүү чанар өндөр – (homogeneous nature of risk)
2. Бага хураамжтай олон худалдан авагч – (more in number of buyers; small premium per buyer)

Дээрх онцлог шинжүүд Даатгалын компанийн үйл ажиллагаа өндөр хурдтай, бүтээмжтэй байхыг шаарддаг.

Энэхүү шаардлагыг хангахын тулд ухаалаг даатгалын компаниуд Мэдээлэл Технологийг үйл ажиллагааны процессыг хурдасгах, амарчлах багаж болгож ашиглаж байна.

- Андеррайтинг, үнийн санал (=quotation) боловсруулах үйл явцыг компьютер системжүүлж хурдасгах
- Даатгалын гэрээний стандарт төслүүд боловсруулж, тухай төслийн архивыг компьютер системтэй холбох; ингэснээр даатгуулагч бүрийн хувийн мэдээллийг автоматаар шивж гаргадаг болох
- Хураамжийн нэхэмжлэх, гэрээний нэмэлт/өөрчлөлт, сунгалтын сануулга гэх мэт админ үйл явцыг автоматжуулах



1.3 – Багц даатгалын бүтээгдэхүүний хөгжилд Мэдээлэл Технологийн ашиг тус (2)

Сүүлийн үед олон улсын даатгалын зах зээлд ажиглагдаж буй зүйлс:

1. Хиймэл Оюун ухаан (AI), Дата Аналитикыг даатгалын үйлдвэрлэлд ашиглаж тогтсон практикыг өөрчлөх оролдлогууд
2. Өөрөө өөртөө туслах онлайн даатгалын дэлгүүр.
3. Хараат бус даатгалын брокер үнэ цэнээ хадгалж байгаа байдал.



1.4 – Хяналт, Зохицуулалтын Байгууллагын Оролцоо

- ✓ Урьдчилж арга хэмжээ авах, санаачлагатай байх хандлага – Английн FCA (Financial Conduct Authority) –н туршлага, арга барил
- ✓ SME Бизнесүүдийн Даатгалын нөхөн төлбөрийг даатгалын компаниуд хэрхэн шийдвэрлэж буй байдалд хийсэн өргөн цар хүрээтэй шалгалт, судалгааны ажил – 2015
- ✓ 2020-2021 онд болсон Ковидоос улбаатай бизнес тасалдлын Даатгалын нөхөн төлбөрийн маргааныг шүүх хэрхэн шийдсэн байдал, FCA даатгуулагчдыг төлөөлж нэхэмжлэгч талд оролцсон байдал
- ✓ Fair Treatment of Customer – Үйлчлүүлэгчид үнэнч, шудрага хандах



1.5 – Хэрэглэгчид сайнаар, итгэмжит байдлаар хандах зарчим fair treatment of customer

Fair гэж

- Ялгаваргүй, эрх тэгш, шудрага хандах.
- Хуурч мэхлэхгүй, төөрөгдүүлэхгүй байх; сул тал, мэдлэг дутууг нь ашиглаж өөрт таатай нөхцөл байдал үүсгэхгүй байх.



1.5 – Хэрэглэгчид сайнаар, итгэмжит байдлаар хандах зарчим Даатгалын компани яагаад “fair” хандах үүрэгтэй вэ?

- Бүтээгдэхүүнийг даатгагч боловсруулдаг
- Олон улсын сайн хөгжлийн дагуу бол SME Бизнесийн Даатгал нь сайн дурын даатгал байх тул даатгагч борлуулалт хийж, гэрээний харилцаанд ятгаж оруулдаг.
- Банк, Банк бустай хамтрах замаар даатгуулагчид өөрийн боловсруулсан нөхцөл бүхий гэрээг шахдаг.
- АЖД гэх мэт заавал даатгал үүсгэдэг.
- Саалиа бэлдэхээр саваа бэлд буюу дэмжих дэд бүтцүүдийг даатгагч өөрсдөө бий болгох манлайлах үүрэг.
- Даатгалын үйлчилгээ юу? төрийн үйлчилгээ юу? – Эрх бүхий байгууллагаар шийдүүлнэ гэж өөрөөс зайлуулсан шинжтэй хандлага



1.5 – Хэрэглэгчид сайнаар, итгэмжит байдлаар хандах зарчим

АСУУДАЛ – Эрх бүхий байгууллага

Эрх бүхий байгууллагаар шийдүүлнэ гэж өөрөөс зайлуулсан шинжтэй байдал нь эргээд даатгагчид хүндрэл үүсгэдэг. Даатгалын салбарыг төвөгтэй харагдуулдаг.

Жишээлэхэд Даатгалын компани даатгуулагчийн хохирлыг нөхөн төлөөд буруутай этгээдээс хохирлоо нэхэмжлэх гэхээр замын цагдаа зөвхөн хэргийн оролцогчид хэргийн материалыг гаргаж өгнө гээд даатгалын компанид материал гаргаж өгдөггүй, эрхээ хэрэгжүүлэхэд нь хүндрэл үүсгэдэг. Нөгөөтээгүүр, энэ нь даатгуулагчид ч хүндрэлтэй байдал үүсгэдэг.



1.5 – Хэрэглэгчид сайнаар, итгэмжит байдлаар хандах зарчим Fair Treatment-тэй холбоотой FCA-н арга барил

- Treating Customer Fairly гэж хөтөлбөр хэлбэрээр 10-д жилийн өмнөөс оршиж байсан
- Одоо Даатгалын компанийн суурь шаардлага болж хөгжсөн.
- Fair treatment of customer гэж:
 - ✓ Үйлчлүүлэгчид өгөх зөвлөгөө нь үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлыг ойлгож, түүнд зориулсан байх
 - ✓ Үйлчлүүлэгчид нийлүүлэх даатгалын бүтээгдэхүүн нь тухайн үйлчлүүлэгч эсвэл үйлчлүүлэгчдийн сегментийг таньж мэдсэн, судалж ойлгосон, хэрэгцээ шаардлагад тохирсон байх
 - ✓ Даатгалын компани эздийн, удирдлагын түвшинд “fair treatment of customer”-н шаардлагыг ухамсарлаж ойлгож, компанийн суурь үнэт зүйл болгож ажиллах
 - ✓ Үйлчлүүлэгчдээс ирдэг fair treatment-тэй холбоотой гомдлуудыг суурь шалтгаанаар нь судалж, таньж, асуудлыг үндсээр нь шийдсэн байх



1.5 – Хэрэглэгчид сайнаар, итгэмжит байдлаар хандах зарчим Fair Treatment-г ухамсарлаж ажилладаг сайн даатгалын түгээмэл шинжүүд

- Компанийн үйл ажиллагааны утга учир нь бүх ажилтнуудад тодорхой, маш ойлгомжтой танигдсан.
- Алдаа дутагдлыг, асуудлыг нууж дардаггүй, дэлгэж чаддаг.
- Үр дүнтэй удирдлага ба засаглал
- Чухал, шаардлагатай үр чадварыг бүрэн эзэмшсэн ажилтнуудтай ба шудрага, хариуцлагатай, зохистой урамшууллын системтэй
- Fair treatment of customer ойлголт компанийн бүх үйл ажиллагааны түвшинд хэрэгждэг. Зөвхөн борлуулалтын үед хэрэгжээд өнгөрдөг биш. Бүтээгдэхүүн боловсруулах, зохион үе, нөхөн төлбөрийн нэхэмжлэл шийдвэрлэх үе гээд бусад бүхий л түвшинд үйлчлэх



1.5 – Хэрэглэгчид сайнаар, итгэмжит байдлаар хандах зарчим Английн нэг даатгалын компанийн гэрээний загварт тусгагдсан амлалт

Манай компани үйлчлүүлэгчдээ “fair” хандаж, харьцаж ажиллахаар эрс шийдсэн.

Заримдаа нөхцөл байдал бодсоноос өөрөөр эргэх үе байдаг. Манай даатгалын компани таны санал гомдлыг “маш серёзны” авч үзэх ба үйлчлүүлэгч бүрийнхээ асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэхээр ажиллах болно.

PROMISE TO THE INSURED

Committed to treating customers fairly. However the Insurers realise that things can go wrong. The Insurers take complaints seriously and aim to resolve all of our customers' concerns as quickly as possible.

If you do not meet with your requirements please return all of the documents and the Insurance to your Broker Intermediary or Agent who has arranged the cover.

If you wish to terminate the cover at any time you should contact the Broker Intermediary or Agent. If there have been no claims the Insurers will refund a proportionate part of your premium. If a Liability Section has been arranged on a minimum and deposit basis in which case the Insurers will refund the premium for that Section.

1.5 – Хэрэглэгчид сайнаар, итгэмжит байдлаар хандах зарчим Санхүүгийн бүтээгдэхүүн хэрэглэгчдийг хамгаалах тухай нэмэлт шаардлага

FCA-нь Fair Treatment of Customer шаардлагын хүрээнд хэрэглэгчдийг санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний алдаа дутагдал, зөрчлөөс хамгаалах нэмэлт шаардлага, хяналт зохицуулалтыг даатгагчдад тавьдаг.

FCA даатгалын компаниуд дараах хохирлуудыг (=harm) хэрэглэгчдэд бий болгож байна гэж дүгнэсэн.

- Иргэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд үргэлж, заавал нарийн сайн бодож, тооцсон шийдвэр гаргаж чаддаг байх албагүй. Тийм учраас үүнийг санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэгч өөрт таатай байдлаар ашиглах нь зөв зүйл мөн үү?
- Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний байгууллагууд хэрэглэгчийн үнэнч зан (=loyalty), хүчин чадал, цаг бага (=inertia) байдлыг өөрт таатай байдлаар ашиглах байдал
- Даатгалын компаниуд бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийдэггүй. Эсвэл хийхдээ хэрэглэгч тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэнэ буюу нөхөн төлбөр төлнө гэж бодож, энэ нь үйлчилгээ гэдгийг ойлгож, ухамсарлаж ханддаггүй харин илүү борлуулалтын орлогыг боддог байдал.
- Рекламдаж, зарж буй бүтээгдэхүүн ба түүнийг хүргэх, мэдрүүлэх үйлчилгээнүүд нь “fair value” муутай байх

1.6 – Бүрэн стандартчилсан ба хагас стандартчилсан полиси Бизнесийн Багц Даатгалын давуу тал

<p>Даатгуулагчид үүсэх давуу талууд</p>	<ul style="list-style-type: none">• Нэг “эрсдэлийн асуулгаар” (questionnaire form) бүх олон өөр даатгалын эрсдэлийн мэдээллийг нэг дор цуглуулах• Цаг хэмнэлт: олон төрлийн даатгалуудыг өөр өөр хугацаанд сунгахгүй нэг ижил хугацаанаас бүх даатгалын хамгаалалтууд зэрэг эхлэх тул цаг хэмнэнэ.• Хялбар: даатгал бүрт зориулсан гэрээ гэхгүй нэг гэрээнд бүх даатгалуудыг багтааснаар уншиж танилцахад хялбар.• Тусгайлж зориулсан тул ойлгомжгүй, тодорхойгүй, салаа утга бүхий заалтууд багасна.• Хураамж хямдрах боломжтой.• Зориулсан бүтээгдэхүүн тул хамгаалалтын хийдэл, дутуудал арилна.
<p>Даатгагч/Брокерт үүсэх давуу талууд</p>	<ul style="list-style-type: none">• Үйл ажиллагааны зардал буурна.• Ажилтнууд мэргэшиж, техникийн ур чадвар сайжрана.• Борлуулах итгэл үнэмшил, урам нэмэгдэнэ.



1.6 – Бүрэн стандартчилсан ба хагас стандартчилсан полиси Combined vs Packaged Policy (1)

Өөр өөр даатгалын бүтээгдэхүүнийг нэг бичиг баримтад багтаасан бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг combined эсвэл packaged гэсэн хоёр байдлаар хийж байна.

Combined гэж

Бизнесийн эрсдэлүүд, бизнес буюу байгууллагын даатгалд зориулсан анхны полиси бол combined policy байдлаар зах зээлд нэвтэрсэн.

Хэдийгээр нэг гэрээ буюу нэг бичиг баримтаар явдаг ч тухайн гэрээнд агуулагдах даатгал бүрийг тус бүрээр нь андеррайт хийж, даатгал тус бүр өөрийн хураамжийн хувь, өөрийн нөхцөлүүд агуулсан байдаг.

Combined загвар дунджаас-том (medium – large firms) хэмжээтэй компаниудад илүү тохиромжтой байдаг.



1.6 – Бүрэн стандартчилсан ба хагас стандартчилсан полиси Combined vs Packaged Policy (2)

Combined Policy-д дараах төрлийн даатгалууд ихэвчлэн хамрагдсан байдаг.

- Хөрөнгө (=Property Damage)
- Бизнес Тасалдал (=Business Interruption)
- Ерөнхий Хариуцлага (=Public Liability) – Энэ төрөлд мөн Ажил олгогчийн Хариуцлагын оруулдаг.
- Ажилтны гэнэтийн осол, тэтгэмж (=Personal Accident/Worker's Compensation)
- Ачааны даатгал (=Cargo and Stock)
- Мэргэжлийн Хариуцлага (=Professional Indemnity)



1.6 – Бүрэн стандартчилсан ба хагас стандартчилсан полиси Combined vs Packaged Policy (3)

Packaged Policy загвар нь хувь бизнес эрхлэгч, бичил бизнес, жижиг-дунд бизнес эрхлэгчдэд түлхүү чиглэгдсэн байдаг.

Маш ойлгомжтой, хялбар, тодорхой цөөн үгтэй нэг гэрээний бичиг баримтаар үндсэн 3 даатгалын хамгаалалтыг стандартчилж нэгтгэсэн загвар юм. Тийм учраас андеррайтинг бүтээгдэхүүн тус бүр дээр хийгдэхгүй; бүтээгдэхүүн тус бүрт зориулсан хураамж бодогдохгүй.

Ихэвчлэн нэг суурь, доод хураамжтай байдаг

Суурь гурван хамгаалалт:

- Бизнесийн хөрөнгө (үүнд хулгай, мөнгө, шилний хамгаалалт нэмэлтээр үнэлгээний дэд-хязгаартайгаар оруулж болдог)
- Орлого тасалдал
- Ерөнхий хариуцлага



1.6 – Бүрэн стандартчилсан ба хагас стандартчилсан полиси Combined vs Packaged Policy (4)

Packaged Policy-д тохирох бизнес, үйл ажиллагааны төрлүүд:

1. Байрны доор байрлах дэлгүүр
2. Жижиг буудал, караоке, лаунж, ресторан
3. Хоолны газрууд
4. Жижиглэнгийн барааны дэлгүүр, лангуу
5. Ломбард
6. Гэрэл зурагчин, канон, принтер, нотариат
7. Шүдний эмнэлэг, эмийн сан



1.6 – Бүрэн стандартчилсан ба хагас стандартчилсан полиси Combined vs Packaged Policy (5)

Даатгалын бүтээгдэхүүний төрлүүд

Голлох онцлогүүд

Combined Policy

- Хооронд нь нийлүүлж болохуйц урьдчилж боловсруулсан гэрээнүүд бүхий хувилбар
- 5-50 сая доторх хураамж
- Дунджаас дээш эсвэл эрсдэлийн ижил чанар дундаж түвшний бизнес, байгууллагуудад тохирсон
- Өөр өөр размерын бөгөөд хэрэглэгч бүрт зориулж чимхлүүр өөрчлөлтүүд хийх боломжтой
- Үнэлгээ, өөрийн хариуцах хэсгийн хязгаар, хэмжээг тохиролцож өөрчлөх боломжтой

Packaged Policy / SME

- шууд зарахад бэлэн болгож стандартчилсан, бэлэн гэрээнүүд
- 5 саяас доош хураамж
- Эрсдэлийн ижил чанар өндөр
- Нэг размерын буюу хэрэглэгч бүрт зориулж өөрчлөх боломжгүй
- Урьдаас тогтсон үнэлгээ, өөрийн хариуцах хэсгийн хязгаарууд

1.7 – Дэмжих үйлчилгээнүүд

Эрсдэлийг хянах,
удирдах үйлчилгээ

Call center, зөвлөгөө
өгөх үйлчилгээ,
хэрэглэгчийн санал,
гомдол хариулах

Албан ёсны засвар,
сэлбэг
нийлүүлэгчийн
сүлжээ



1.7 – Дэмжих үйлчилгээнүүд Эрсдэлийг хянах, удирдах – Risk Control services

Эрсдэлийг таньж мэдэх, тохиолдох магадлал болон хохирлын хүрээг өндөр байлгах аюулуудыг тогтоох, аюул эсвэл эрсдэлийг багасгах, бууруулах, зайлуулах, үр дагаврыг тооцоолох цогц үйл явц, технологийг “risk control” гэнэ.

Энэ үйл явц даатгуулагч, даатгагч аль алинд нь ашигтай зүйл.

Гэвч даатгуулагч эрсдэлд илүү хойрго, эсвэл даатгагчтай харьцуулбал мэдлэг, мэдээлэл сул тул даатгалын компани эрсдэлийн контрол үйлчилгээг санаачлагатай нэвтрүүлж ажиллах нь ухаалаг зөв хандлага байдаг.

Даатгалын компани туршлага, мэдлэг, мэдээлэл, харилцаа холбоо, санхүү, хүний нөөцөө ашиглаж эрсдэлийн контролын технологиудийг боловсруулж даатгуулагч бизнес эрхлэгчдэд эрсдэлээ бууруулах, удирдахад туслалцаа үзүүлэх боломжтой.



1.7 – Дэмжих үйлчилгээнүүд

Call Center, Санал гомдолд хариулах, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үйлчилгээ

Даатгалын байгууллагууд дараах байдлаар даатгуулагч үйлчлүүлэгчиддээ халамж үйлчилгээ үзүүлдэг.

Нөхөн төлбөртэй холбоотой:

- Хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр шийдэх хөрөнгө, ердийн даатгал хариуцсан мэргэжилтэн
- Машин механизмын даатгал, эвдрэл, хэмхрэлийн нөхөн төлбөр шийдэх инженерийн нөхөн төлбөрийн мэргэжилтэн
- Хариуцлагын даатгалын нөхөн төлбөр, болзошгүй тохиолдлыг хариуцах албан ёсны хууль зүйн туслалцааны фирм

Бусад төрлийн нэмэлт туслалцаа үйлчилгээ. (Жижиг дунд бизнесүүд том бизнесийг бодвол дэмжих үйл ажиллганы нэгж байдаггүй тул даатгалын компани нэмэлтээр дэмжих үйлчилгээний туслалцааг үзүүлж болдог)

Ингэхийн тулд даатгалын компани нь татвар, хууль, хүний нөөц, сэтгэл судлал гэх мэт олон дэмжих, туслах мэргэжлийн байгууллагуудтай урьдчилж хамтын ажиллагааны дэд бүтэц байгуулах замаар эдгээрийг хийдэг.

- Татварын зөвлөгөө
- Бизнесийн хууль зүйн зөвлөгөө
- Хүний нөөцийн туслалцаа, зөвлөгөө



Бүлэг 2 – Багц Даатгалын Суурь Бүтээгдэхүүнүүд

- 2.1 Хөрөнгийн Даатгал
- 2.2 Даатгалд хамрагдах хөрөнгүүд ба бизнесийн хөрөнгийн орших хэлбэрүүдийг таньж мэдэх
- 2.3 Даатгалд хамрагдах эрсдэлүүд
- 2.4 Нэмэлт хамгаалалтууд (Extensions)
- 2.5 Хасалтууд
- 2.6 Бизнес Тасалдлын Даатгал
 - Борлуулалт ба үйлчилгээний хөлс
 - Үйл ажиллагааны нэмэгдэл зардал, өртгийн хамгаалалт – Increased cost of working
 - Бизнес Тасалдлын нэмэлт хамгаалалтууд (Extensions)
 - Бизнес Тасалдлын хасалтууд
- 2.7 Хариуцлагын Даатгал
 - Хариуцлагын даатгалын суурь философи ба түүний ажиллах зарчим
 - Хариуцлагын даатгалын хэлбэрүүд ба тэдгээрийн онцлог
 - Мэргэжлийн хариуцлагын даатгал ба түүний онцлог зарчмууд
 - Хариуцлагын даатгалын ерөнхий хасалтууд

Бүлэг 2: 2.1 – Хөрөнгийн Хамгаалалт (Property Cover)

Хамгаалах эрсдэлүүд	All-Risk basis Бүх Эрсдэл	Named Peril Нэрлэсэн Эрсдэл
Хамгаалах хөрөнгүүд	<ol style="list-style-type: none"> 1. Үл хөдлөх хөрөнгө, дотор засал, тохижилт 2. Компьютер эд хогшил, тавилга 3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж 4. Бараа материал 	
Үнэлгээ	<p>Даатгагч хөрөнгийг төрлөөр нь урьдчилж судалж, тухайн үеийн зах зээлийн үнэлгээний ойлголттой болсон байдаг.</p> <p>Тийм учраас үнэлгээг урьдаас шаталсан байдлаар тогтоож бэлддэг.</p>	
Хураамж	<p>Хөрөнгийн төрөл, онцлог, үнэлгээг урьдаас сайтар судалж, тогтоосон дээр үндэслэж даатгагч хураамжийг урьдаас мөн адил шаталсан байдлаар тогтоодог.</p>	



2.2 – Биет хөрөнгийн төрлүүд ба үнэлгээ

	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3	Шатлал 4
Үл хөдлөх, дотор засал, тохижилт	500,000,000	1,000,000,000	2,000,000,000	5,000,000,000
Бараа, материал	250,000,000	500,000,000	1,000,000,000	2,000,000,000
Тоног төхөөрөмж	250,000,000	500,000,000	1,000,000,000	2,000,000,000
Компьютер эд хогшил, тавилга	100,000,000	200,000,000	350,000,000	500,000,000



2.3 – Хамгаалах Эрсдэл / Perils Covered

Түгээмэл Хувилбар – Бүх Эрсдэл хамгаалалт

Даатгалын гэрээний Хасагдах хэсэгт дурдсан нөхцөлүүдээс бусад бүх төрлийн эрсдэлийн улмаас Хавсралтад заасан хөрөнгөд гэнэтийн, санамсаргүйгээр биет хохирол учирвал даатгагч өөрийн сонголтоор тухайн хохирлыг даатгалын үнэлгээнд багтаан мөнгөн эсвэл засварлах, солих, нөхөн сэргээх, орлуулах хэлбэрээр даатгуулагчид нөхөн төлнө.

Өөр Хувилбар – Нэрлэсэн Эрсдэл хамгаалалт

Гал, дэлбэрэлт, газар хөдлөл гэх мэт эрсдэлийг тоочих хувилбар.



2.3 – Хамгаалах Эрсдэл / Perils Covered

Бүх эрсдэл хамгаалалт + Инженерийн
даатгалын хамгаалалт

Түгээмэл болж ирсэн хамгаалалт

Гал + бусад нэрлэсэн эрсдэлүүд +
Инженерийн даатгалын хамгаалалт

Үндсэн хамгаалалт дээр нэмж
угсардаг

Галын хамгаалалт

Үндсэн хамгаалалт (Уламжлалт
эрсдэл)



2.4 – Үнэлгээ

- Үнэлгээг тогтсон хоёр төрлийн хувилбарын үнэлгээг үндэслэл болгож хэвшсэн.
 - Бодит үнэлгээгээр нөхөн олгох – pure indemnity basis
 - Нөхөн сэргээх, орлуулах – reinstatement basis

Барилга байгууламж, түүний бүрдэл хэсгүүд	Олон давтамжтай, богино хугацаанд зарагдаад байдаггүй тул зах зээлийн үнэлгээг тогтоох төвөгтэй. Иймд <u>reinstatement</u> , <u>replacement as new</u> хувилбар хялбар бөгөөд тохиромжтой байдаг.
Тавилга, тоног төхөөрөмж, эд хогшил	Зах зээлийн үнэлгээ нь reinstatement/replacement үнэлгээнээс доогуур байх тул даатгалын зорилгод reinstatement/replacement as new үнэлгээ тохиромжтой
Бараа, материал	Replacement as new Жижиглэн худалдагчийн хувьд бөөний захын үнээр, бөөний захийн худалдагчид эцсийн нийлүүлэгчийн үнээр, эцсийн нийлүүлэгчид үйлвэрлэгч эсвэл нийлүүлэгч өөрөө үйлдвэрлэгч бол үйлдвэрийн бараа материалын өртгөөр



2.4 – Нэмэлт хамгаалалтууд

<p>Үнэлгээг сэргээх нөхцөл / <i>automatic reinstatement clause</i></p>	<p>Даатгалын гэрээгээр нөхөн төлбөр авсны дараа үнэлгээг нэмэлт хураамжгүйгээр эсвэл тодорхой дүн дотор нэмэлт хураамжгүйгээр сэргээх тухай</p>
<p>Мэргэжлийн ажил үйлчилгээний зардал / <i>Professional Fees Clause</i></p>	<p>Хохирсон даатгалын зүйлийг нөхөн сэргээх эсвэл солиход холбогдон гарах зураг төсөл, төсөв, тооцолол, хууль зүйн мэргэжлийн үйлчилгээний зардлыг даатгалын нөхөн төлбөрт тооцох тухай</p>
<p>Хог хаягдал зайлуулах зардал / <i>Debris Removal</i></p>	<p>Даатгалын зүйл даатгалд хамаарах эрсдэлийн улмаас сүйрэх эсвэл хохирсны улмаас үүсэх нураах, хог хаягдлыг зайлуулах, талбайг цэвэрлэх зардлыг нөхөн төлөх тухай</p>
<p>Төр, захиргааны байгууллагын шийдвэр / <i>Public Authority</i></p>	<p>Төр захиргааны байгууллагын шийдвэрээс улбаатай хохирол</p>
<p>Нөхөн төлбөрийн урьдчилгаа / <i>Payment on Account</i></p>	<p>Даатгалын тохиолдлын шалтгаан нь гэрээнд хамаарахаар тогтоогдсон боловч хохирлын хэмжээг тогтоох үйл явц удаан үргэлжлэх нөхцөл байдалд даатгуулагчийн хүсэлтийг үндэслэж даатгагч нөхөн төлбөрийг тодорхой хэмжээгээр урьдчилж олгож болдог.</p>

2.5 – Хөрөнгийн Даатгалын хасалтууд

- Дайн, терроризм
- Үнэт эдлэл, ховор, үнэтэй бүтээл, цуглуулга
- Шил
- Цахим эрсдэл
- Ердийн элэгдэл хорогдол
- Механикийн, цахилгааны эвдрэл
- Тайлбарлагдах боломжгүй хохирол, залилан луйвар
- Даатгуулагчийн өөрийн ажилтан, захирал, эзэний хулгай
- Ил задгай орчинд байрлуулсан, байралдаг зөөврийн эд хогшил, хөрөнгөд байгалийн гамшгаас учирсан эрсдэл



2.6 – Бизнес Тасалдлын Даатгал

Хөрөнгөд хохирол учирвал дагаад бизнес тасалддаг тул бизнес тасалдлын даатгалын хамгаалалт даатгуулсан хөрөнгөнд хохирол учирснаас үүдэлтэй алдагдсан орлогыг нөхөн төлөх зориулалттай юм.

Рестораны үйл ажиллагааг жишээ авъя. Санаандгүйгээр гал алдсанаас болж багадаа 2 сар үйл ажиллагаа зогсоход хүрсэн. Энэ хугацаанд ажилчдын цалин, талбайн түрээс гэх мэт тогтмол болон хохирлоос улбаатай шинээр зардлууд гарч байдаг. Харин бизнес зогссон тул орлого орохгүй. Тиймээс тогтмол зардлуудаас гадна тухайн хугацаанд олох байсан цэвэр ашгаар бизнесийн эзэн хохирч байна.



2.6 – Бизнес Тасалдлын Даатгал

Хамгаалалтууд

- Орлого (Цэвэр ашиг + тогтмол зардал)
- Бизнесийн тасалдлыг бууруулах буюу үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхийн тулд зарцуулсан нэмэлт зардлууд

Үндсэн Шаардлага – даатгалын зүйл буюу даатгуулсан хөрөнгөд даатгалын гэрээгээр тохирсон эрсдэл тохиолдож хохирол учирсан байх.



2.6 – Бизнес Тасалдлын Даатгал

Орлогын хамгаалалт

- **Борлуулалт (Gross Profit)**
 - Бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч худалдааны, үйлдвэрлэгч байгууллагуудад тохирдог.
 - Бараа бүтээгдэхүүний өртгийг хасаж борлуулалтын цэвэр орлогыг гаргаж үүнээс хувьсах зардлууд буюу даатгалд хамрагдахгүй зардлуудыг хасаж цэвэр ашиг, тогтмол зардлуудлыг авч тооцно. Даатгалд хамрагдахгүй зардал гэдэг нь бизнес тасалдахад дагаад хамт тасалддаг хувьсах шинжтэй зардлууд гэж ойлгодог.
- **Төлбөр, хөлс (Gross Fees)**
 - Үйлчилгээний байгууллагад тохирдог. Бараа бүтээгдэхүүн зардаггүй тул цэвэр оюуны хөдөлмөр, үйлчилгээгээ үнэлж хөлс, шимтгэл, төлбөр байдлаар орлого бүрддэг.
 - Ийм тохиолдолд бараа бүтээгдэхүүний өртөг гэсэн хасалт хийгдэхгүй. Зөвхөн хувьсах зардлуудыг тооцох боломжтой

2.6 – Бизнес Тасалдлын Даатгалын нэмэлтүүд

- Контингент Бизнес Тасалдал
 - Контингент Бизнес Тасалдал нь даатгалын зүйлд биет хохирол учирснаас биш харин нийлүүлэгчийн гинжин хэлхээнд буюу өөр нэг тал үүргээ биелүүлээгүйгээс болж даатгуулагчийн бизнес тасалдаж буй нөхцөл байдал юм.
- Даатгалын зүйлийн эргэн тойрны хөрөнгөд хохирол учирснаас үүдэн даатгалын зүйл рүү нэвтрэх боломжгүй болсноос үүдсэн бизнесийн тасалдал
- Хүн амьны хэрэг, амиа хорлолт, халдварт өвчин – Ковидоос хойш халдварт өвчин стандарт хасалтад орох болсон



2.7 – Хариуцлагын Даатгал

- Хайхрамжгүй, болгоомжгүй (careless, negligent) үйлдэл, эс үйлдэл нь бусдад гэм хор учрах шалтгаан, нөхцөлийг үүсгэж байдаг. Иймд Иргэний Хуулийн дагуу бусдад учирсан гэм хорын хариуцлагыг буруутай тал хүлээж, хохирлыг барагдуулах ёстой болдог. Энэхүү хариуцлагаас даатгуулагчийг чөлөөлж, учирсан гэм хор, хор уршгийг нөхөн төлөх нь хариуцлагын даатгалын ерөнхий үзэл санаа.
 - Ажил олгогчийн Хариуцлага
 - Ерөнхий хариуцлага
 - Бүтээгдэхүүний Хариуцлага
 - Мэргэжлийн Хариуцлага
 - Амбрелла хариуцлага
- Ямар нэг алдаа, зөрчил гарахгүйгээр хариуцлага үүсэх боломжгүй.



2.7 – Хариуцлагын Даатгал

- “ordinary negligence that is central to liability policies”- Кэмбриджийн Их Сургуулийн Бизнесийн Хуулийн Багш Малколм А. Кларк - Хариуцлагын Даатгалын Хууль ном
 - Ordinary negligence гэж хайхрамж, болгоомжгүй байх тухай. Үүнээс болж алдаа, зөрчил гарна. Муу үр дагаварт хүргэж болох эрсдэлийн түвшинг нэмэгдүүлсэн орчин, нөхцөл байдал (increase of exposure) тухайн хайхрамж, болгоомж алдагдахад бий болно.
 - Гэм хор буюу эдийн, эдийн бус хохирлууд бол үр дагаврын илэрхийлэгдэх байдал. Үр дагавар шууд тэр дороо илэрч болно эсвэл удаан хугацааны дараа илэрч болно.



2.13 – Хариуцлагын Даатгалын ажиллах зарчим

- Даатгуулагчийн эсрэг үүссэн гомдол, нэхэмжлэлийг даатгуулагчийн өмнөөс хүлээн авч даатгуулагчийг чөлөөлөх үйл явц
 - Хөндлөнгийн хуулийн фирмийн үйлчилгээ
 - Хөндлөнгийн гомдол, нэхэмжлэлтэй харьцдаг үйлчилгээ /ТРА/
- Даатгуулагчийн эсрэг үүссэн гомдол, нэхэмжлэлийг судалж, үндэслэлтэй бол хохирлын үнэлгээг тогтоож нөхөн олговрыг олгоно.
 - Гомдол, нэхэмжлэлийн онцлог, дүн зэргийг харгалзаж даатгуулагчийн саналыг дэмжиж шийдэх эсвэл даатгагч гомдол, нэхэмжлэлийг өөр дээрээ шилжүүлж авч шийдвэрлэнэ.
- Эцсийн зорилго нь даатгагч өөрөө хайхрамж, болгоомж алдсан юм шигээр ойлгож даатгуулагчийн гэм буруутай эсэх байдлыг өөр дээрээ авч ажиллах тухай үзэл санаа юм.



2.7 – Хариуцлагын Даатгалын ажиллах зарчим

Ердийн Хариуцлага / Бүтээгдэхүүний Хариуцлага

- Гэм хор учруулснаас үүсэх эдийн хохирол, эдийн хохирлоос үүсэн бий болох эдийн бус хохирлыг төлөхөөр ойлгодог.
 - Гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд (алдагдсан орлого) шууд учирч буй хохирлыг эдийн хохирол гэж үзэх
 - Энэхүү хохирлоос болж гуравдагч этгээдэд үүсэх сэтгэл санааны хохирлыг эдийн бус гэж үзэх



2.7 – Хариуцлагын Даатгалын ажиллах зарчим

Ажил Олгогчийн Хариуцлага

Олон улсад	Монголд
<p>Ажилтны Нөхөн Олговрын Тогтолцоо (Workers Compensation) хуулиар урьдаас тогтсон дүнгээр аливаа осол аваарт орвол ажилтанд нөхөн олговор олгодог.</p> <p>Ажил Олгогчийн Хариуцлага гэж ажилтан тухайн нөхөн олговорт багтаагүй эсвэл олгох дүнтэй санал нийлээгүй тохиолдолд ажил олгогчийн эсрэг нэхэмжлэл гаргах тухай ойлголтыг хэлнэ</p>	<p>Ажил олгогчийн хариуцлага гэж Хөдөлмөрийн Хуульд заасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөхөөр ойлгодог.</p> <p>Энэ нь Worker's Compensation-г илэрхийлдэг. Иймд Ажил Олгогчийн Хариуцлага гэж нэрлэх нь буруу ойлголт үүсгэж байна.</p>



2.7 – Хариуцлагын Даатгалын ажиллах зарчим

Ажил олгогчийн хариуцлага - Жишээ

Ажилтан нас барснаас болж түүний гэр бүл хань ижлээ алдсанаас үүсэх сэтгэл санааны хохирлыг ажил олгогчоос нэхэмжилсэн.

Loss of Consortium



2.7 – Хариуцлагын Даатгалын ажиллах зарчим

Мэргэжлийн Хариуцлага / Эмч, Эмнэлгийн Мэргэжлийн Хариуцлага

- Professional (Мэргэжилтэн) гэдэг үгийн утгыг (Мэргэжлийн Алдаа ба Хариуцлага номонд)
 - Онцгой, тусгай ур чадварт суралцаж, туршлагажиж, улмаар тухайн онцгой, тусгай ур чадварыг бусдад үйлчилгээ болгож үзүүлэх үйл явц
 - Онцгой, тусгай ур чадвар нь оюуны ба практик дасгал, сургалт, дадлагаар бий болох
 - Мэргэжлийн үйлчилгээ нь үйлчлүүлэгчийг төлөөлж, түүний өмнөөс шийдвэр гаргах, бодож тооцож боловсруулж өгөх өндөр түвшний итгэл хүлээсэн, бие даасан байдлыг бий болгодог.
 - Мэргэжлийн үйлчилгээ нь үйлчлүүлэгчтэй хувьчилсан харилцаа үүсгэж, нарийн дотно мэдээллүүдтэй нь харьцах, үйлчлүүлэгчийн хөрөнгийг захиран зарцуулах, удирдах зэрэг онцгой итгэлд суурилсан ажлуудыг хамардаг.
 - Онцгой, тусгай ур чадвар нь суралцаж, шалгалт өгч, эрх авдаг байх
 - Онцгой, тусгай ур чадварыг эзэмшигчид өөрийгөө удирдахаар бий болгосон холбоо, мэргэжлийн байгууллагатай. Энэ нь зохих стандарт, ёс зүйн хэм хэмжээ, дүрэм журмыг баталж нийт гишүүн мэргэжилтнүүддээ мөрдүүлэх
 - Мэргэжилтнүүд нь шинэ бизнес, үйлчлүүлэгч татахын тулд бусад төрлийн бизнес, бараа бүтээгдэхүүн дээр явдаг шиг хэт чөлөөтэй маркетинг, реклам явуулахаас татгалзах эсвэл болгоомжлох

2.7 – Хариуцлагын Даатгалын ажиллах зарчим

Profession Мэргэжлийн үйлчилгээний байгууллага	Trade or Business Худалдаа, наймаа, бизнесийн байгууллага
Эзэнд үйлчлэх (Эзэн гэж үйлчлүүлэгч)	Өөрийн эрх ашгийн төлөө
Мэргэжлийн Объектив буюу/эсвэл эзэний эрх ашгийг хангуулахын тулд өөрийн эрх ашгийг тодорхой түвшинд золиослох	



2.7 – Хариуцлагын Даатгалын ажиллах зарчим

Мэргэжлийн Байгууллагууд	Эзэн-Төлөөлийн Байдал
Зураг төсөл, инженер	Үйлчлүүлэгчид барилга, инженерийн зураг төсөл, тооцоог гаргаж өгөх үйлчилгээ
Хуульч, Өмгөөлөгч	Үйлчлүүлэгчийг шүүхэд өмгөөлөх, хууль зүйн зөвлөгөө өгөх, төлөөлж бусадтай тохиролцоо, хэлцэл хийх
Брокер	Үйлчлүүлэгчийн даатгал, үнэт цаасны асуудлаар зөвлөгөө өгөх, захиалга буюу даатгалын гэрээний үнийн санал судлах, гэрээг байршуулах буюу захиалгыг биелүүлэх, нөхөн төлбөр буюу гүйлгээний захиалгуудыг тогтмол биелүүлэх, туслалцаа үзүүлэх
Эмнэлэг	Үйлчлүүлэгчид зөвлөх, шинжилгээ авах оношлох, эмчлэх, асрах, сувилах
Аудит	Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлан балансад хөндлөнгийн, хараат бус тулган баталгаажуулалт хийж өгөх

2.7 – Хариуцлагын Даатгалын ажиллах зарчим

Мэргэжлийн Үйлчилгээ service	Ажил workmanship
Зөвлөгөө, өмнөөс нь хөөцөлдөх, бодож, тооцож, шийдэх, зурж боловсруулах үйл явц	Биет хөрөнгө, бүтээл бий болгох гар ажил



2.7 – Хариуцлагын Даатгалын үндсэн хасалтууд

Ерөнхий Хариуцлага / Бүтээгдэхүүний Хариуцлага

- Тээврийн хэрэгсэл, онгоц, хөлөг онгоцны ашиглалт, эзэмшилтэй холбоотой хариуцлага
- Ур чадвар дутсан ажил, гүйцэтгэлийг засах зардал
- Даатгуулагчийн Хараа, хяналт, мэдэлд байсан гуравдагч этгээдийн хөрөнгө
 - Зарим төрлийн бизнес, үйл ажиллагаанд энэ хасалтыг хамгаалалтад тооцдог. Жишээ нь garage liability буюу машин засвар үйлчилгээний үйл ажиллагаа.
- Мэргэжлийн хариуцлага
- Ажилтанд учирсан хохирол
- Гэрээний дагуу бий болсон үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс үүсэх хариуцлага (бараа бүтээгдэхүүнийг тохирсон хугацаанд нийлүүлээгүй) Гэрээнд тусгасан байх боловч тэгж гэрээнд тусгасан тусгаагүй үл хамааран хуулиар тухайн хариуцлагыг хүлээх үндэслэлтэй тохиолдол хамаарахгүй
- Шүүхээс тогтоосон шийтгэвэр, торгууль
- Алдаатай бараа бүтээгдэхүүнийг эргүүлж татах, оруулах, засах, сэлбэж өгөх зардлууд
- Ажил олгогчийн хариуцлага
- Мэргэжлийн хариуцлага
- Санхүүгийн хохирол

Анхаарал хандуулан оролцсон та бүхэнд баярлалаа.



PROGRES - Promotion of Growth and Employment in the Private Sector

As a federally owned enterprise, GIZ supports the German Government in achieving its objectives in the field of international cooperation for sustainable development.

Published by:

Deutsche Gesellschaft für
Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

Registered offices
Bonn and Eschborn

PROGRES - Promotion of Growth and Employment in the Private Sector

Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

3rd Floor, Building #38, United Nations Street,

4th Khoroo, Chingeltei District,

Ulaanbaatar 210646, Mongolia

T +976 7011 7704

E giz-mongolei@giz.de

I www.giz.de

Author/Responsible/Editor, etc.:

GIZ, PROGRES PROJECT

Design/layout, etc.:

GIZ, PROGRES PROJECT

Photo credits/sources:

GIZ

URL links:

GIZ is responsible for the content of this publication.

In cooperation with:



**MINISTRY OF ECONOMY
AND DEVELOPMENT**

**Deutsche Gesellschaft für
Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH**

Registered offices
Bonn and Eschborn

Friedrich-Ebert-Allee 32 + 36
53113 Bonn, Germany
T +49 228 44 60 - 0
F +49 228 44 60 - 17 66

Dag-Hammarskjöld-Weg 1 - 5
65760 Eschborn, Germany
T +49 61 96 79 - 0
F +49 61 96 79 - 11 15

E info@giz.de
I www.giz.de